

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/15, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 60 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт ёсоор баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Чингэлтэй дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбатад шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, хавсралтын 1-5-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, хавсралтын 6-д заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ч.Однасан/-т, хөрөнгө оруулалтаар бий болсон хяналтын камерын мэдээллийг хот байгуулалтын дундын мэдээллийн санд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 09-ний өдрийн
А/423 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2019 ОНД ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ

				/сая төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
1	Тохижилтын ажил /ЧД, 6 дугаар хороо/	2019	34.8	34.8
2	52, 54 дүгээр байрны дээврийн засвар /ЧД, 6 дугаар хороо/	2019	85.2	85.2
3	Камержуулалт /ЧД, 7 дугаар хороо/	2019	100.0	100.0
4	Гудамж талбайн тохижилт, зам тэгшилгээ /ЧД, 8 дугаар хороо/	2019	100.0	100.0
5	Нийтийн тээврийн зориулалтын зогсоол /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/	2019	50.0	50.0
6	Цагдаагийн хэсгийн албан хаагчдын тусгай хэрэгсэл, техник тоног төхөөрөмж /ЧД, 6, 7, 8 дугаар хороо/	2019	30.0	30.0
	ДҮН		400.0	400.0